

ТЕЛЕВИЗИЙН СЭТГҮҮЛ ЗҮЙН ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛД

Г.Мэндхүү*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхимийн багш, доктор

Түлхүүр үг: телевизийн сувгууд, хөтөлбөр төлөвлөлт, мэдээллийн хөтөлбөр, теле сэтгүүлчдийн ур чадвар, орон нутгийн телевиз, олон улсын суваг, гадаад суртал ухуулга

Одоогоос хориод жилийн өмнө телевиз гэлтгүй, ер нь хэвлэл мэдээллийн салбар нийгэмд зааж сургах, удирдан зохион байгуулах, суртал ухуулга хүргэх үүргээ урьтал болгож байсан. Харин олон ургалч үзлийг уралдуулж, хувь хүний үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг тунхагласнаар телевиз ч бас энэ голдрилыг дагажээ. Сүүлийн жилүүдэд манай орны улс төр, нийгэм, эдийн засаг гээд нийгмийн бүх салбарын харилцаанд гарсан хувьсал нь юуны түрүүнд нийгмийн эд эс болсон хүний ухамсар, сэтгэлгээнд, мөн хүн хоорондын харилцаанд өөрчлөлт авч ирлээ. Нийгэм ямар байна вэ? ОНМХ нийгмийнхээ тусгал нь болох нь гарцаагүй юм.

2,9 сая хүн амтай манай орны хувьд телевизийн тоо дэндүү ахадсан гэдгийг мэргэжлийн судлаачид төдийгүй, жирийн үзэгч ч хүлээн зөвшөөрдөг. Аливаа зүйл ховор байхдаа үнэ цэнтэй байдаг бол элбэгшээд ирэхээрээ

нэр хүнд, үнэ цэнээ алдах тохиолдол бий. Одоогоос хорь гаруй жилийн өмнө телевизийн дэлгэцээр гарч байгаа хүнийг олон нийт хүндэтгэн биширч, үлгэр дуурайлал авдаг байлаа. Харин телевизийн тоо нэмэгдэхийн хэрээр мөнөөх хүндлэл аажмаар бүдгэрэх хандлагатай болж байна. Өнгөц харахад янз бүрийн бүлэг давхаргын сонирхолд нийцсэн дэлгэцийн бүтээл үзүүлдэг телевизийн сувгийн сонголт их болсон мэт харагдаж байгаа ч зайлшгүй анхаарвал зохих асуудлууд байна. Монголын телевизийн салбарт анхаарвал зохих асуудлуудыг хэв шинжээр нь бүлэглэн багцлахыг оролдлоо.

1-рт, уран бүтээлийн хувьд тулгамдсан асуудлыг бүлэглэн тоочиж үзье. Аливаа телевизийн нэвтрүүлгийн сүлжээнд хамгийн чухал байр суурийг мэдээ, мэдээллийн хөтөлбөр эзэлдэг. Судлаачид мэдээг янз бүрээр тодорхойлдог ч эцэстээ нийгмээрээ заавал сонсож мэдсэн байх ёстой чухал мэдээлэл гэдэгтэй санал нийлдэг¹. Тэгвэл телевизийн мэдээллийн хөтөлбөр нь тухай өдрийн хамгийн чухал үйл явдал, үзэгдлийн тухай мэдээний цоморлог болж байна. Дэлхийн олон орны телевизийн туршлагаас харахад

мэдээллийн хөтөлбөрийг хүргэж байгаа хэлбэр, цаг хугацааны хувьд үргэлжлэх байдлыг нь харгалзан үзэж 5-10 минутын богино, 15-30 минут үргэлжилсэн дунд хэмжээний, 60 минут орчим үргэлжилсэн урт хэмжээний гэсэн ангилал төлөвшсөн байдаг².

5-10 минут үргэлжилдэг богино хэмжээний мэдээллийн хөтөлбөр нь цаг үеийн хамгийн чухал үйл явдлын тухай мэдээ, мэдээллийг үзэгчдэд хүргэж чаддаг давуу талтай.

24 цагийн турш эфиртэй мэдээллийн сувгууд 15-30 минут үргэлжилсэн дунд хэмжээний гэж нэрлэгддэг мэдээллийн хөтөлбөрийн хэлбэрийг сонгодог байна. Тухайлбал: Их Британийн BBC World суваг, АНУ-ын CNN, Катарын "Аль-Жазира" зэрэг теле сувгууд цаг бүрийн эхний 30 минутад мэдээллийн хөтөлбөрөө шууд толилуулж, үлдсэн хугацаанд нь урьдчилан бэлтгэсэн нэвтрүүлэг үзүүлдэг практик нэгэнт төлөвшсөн байна.

Урт хэмжээний мэдээллийн хөтөлбөр 60 минут үргэлжилдэг. Бүтэн нэг цагийн турш үргэлжилдэг мэдээллийн хөтөлбөрийг АНУ-ын CBS телевизийн уран бүтээлчид анх санаачилсан байдаг. 1968 оны 9 дүгээр сарын 24-нд "60 минут" мэдээллийн хөтөлбөрийн анхны дугаарыг толилуулж байжээ. Мэдээллийн хөтөлбөр нь улс төр, нийгэм, эдийн засгийн амьдралын тухай мэдээ, тусгай сурвалжлага, ярилцлага, шар мэдээ, зурхай, цаг агаарын мэдээ гэсэн бүтэцтэй. "60 минут" мэдээллийн хөтөлбөр нь тогтсон булангуудад хуваагддаг. Булан бүрт өөр өөр хөтөлөгч ажилладаг. Ийм урт үргэлжилдэг мэдээллийн хөтөлбөрийн давуу тал нь цогц мэдээлэл өгч чадна. Харин сул тал нь

үзэгч эхнээс нь дуустал үзэх магадлал бага юм.

Монголын ихэнх арилжааны телевиз "60 минут" форматыг сонгож мэдээллийн хөтөлбөрөө бэлтгэж байна. Бүтэн цагийн турш цэнхэр дэлгэцийн өмнө суугаад мэдээ үзэх нь туйлын тохиромжгүй гэдэг нь хэнд ч ойлгомжтой. Мэдээллийн хөтөлбөр нь цөөн хэдэн сэдвийн хүрээнд эргэлдэж, албаны хүний нуршсан урт яриа үзүүлж үзэгчдийг залхаадаг. Телевизийн мэдээ, сурвалжлагын дүрс нь тун ядмаг, хотын гудамжаар алхаж яваа хүмүүс, гудамж, замын хөдөлгөөн, хотын ерөнхий дүрсээр л хязгаарлагдаж байна. Харин үзэгчдийн сонирхол татахуйц эрчимтэй дүрс мэдээ сурвалжлагад харагддаггүй. Энэ бол бүх телевизэд байгаа нийтлэг дутагдал юм. Мэдээ, сурвалжлагын дүрс ядмаг байгаа нь сурвалжлагчийн бус, харин зураглаач, найруулагчийн хичээл зүтгэл дутсанаас болж байна.

Арилжааны телевизүүд "60 минут" форматыг сонгосон нь цаанаа эдийн засгийн ашиг сонирхолтой ч холбоотой юм. Монгол Улсын Зар сурталчилгааны тухай хуулийн гуравдугаар бүлгийн 11-р зүйлд "Улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаарх тогтмол мэдээллийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно. Үргэлжлэх хугацаа нь 20 минутаас дээшгүй нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно" гэж заасан нь бий. Хэрэв телевизүүд арав, эсвэл 30 минутаас хэтрэхгүй хугацаатай мэдээллийн хөтөлбөр үзүүлэх юм бол дундуур нь зарлал сурталчилгаа үзүүлэх боломжгүй болно. Харин бүтэн цагийн турш үргэлжилсэн олон булан, хэс-

гүүдэд хуваагдсан, бүтцийн хувьд бие даасан тусдаа мэт харагддаг TV-5, 25-р суваг, TV-8 зэрэг телевизийн мэдээллийн хөтөлбөрийн дундуур зарлал сурталчилгаа үзүүлэх боломжтой юм. Арилжааны телевизүүд мэдээллийн хөтөлбөрийн дундуур нэвтрүүлэх зарлал сурталчилгааны үнэ ханшаа ч өндөр тогтоодог.

Улаанбаатар хотод байрлаж, улс орон даяар нэвтрүүлгээ дамжуулдаг телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрт нийслэл хотод өрнөсөн үйл явдлын тухай мэдээ, сурвалжлага зонхилдог. Бид улс орноо зөвхөн Улаанбаатараар төсөөлж болохгүй. Алслагдсан аймаг сумын аж амьдралын тухай мэдээ, сурвалжлагын тоог нэмэгдүүлснээр мэдээллийн хөтөлбөрт тухайн өдрийн дүр зураг цогцоороо бууж ирнэ. Сүүлийн жилүүдэд TV-9 телевиз хөдөө орон нутгийн сэтгүүлчидтэй идэвхтэй хамтран ажиллаж, тэдний бэлтгэсэн мэдээллийг эх орон даяар үзүүлж байгаа нь цаг үеэ мэдэрсэн зөв зүйтэй ажил болжээ. Гэвч хөдөө орон нутгийн сэтгүүлчдийн бэлтгэсэн мэдээ, сурвалжлагын нийгмийн ач холбогдолыг харгалзан үзэх, техникийн болон сэтгүүлчийн ур чадварыг сайжруулахад нь анхаарах хэрэгтэй юм.

Монголын телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрт хилийн чанадад болсон үйл явдлын тухай мэдээ дамжуулахдаа шууд орчуулж байна. Дэлхийн халуун цэг рүү сурвалжлах баг

илгээж мэдээ бэлтгэх нь зардал их шаарддаг тул манай улсын бүх телевизүүд гадаадын телевизээр дамжуулсан мэдээг шууд хуулж орчуулах, эсвэл Ройтерс, Ассошиэйтэд Пресс зэрэг агентлагтай гэрээ байгуулж, албан ёсны зөвшөөрөлтэйгээр дүрстэй мэдээг Интернет, сансрын хиймэл дагуулаас хүлээн авч байна. Хилийн чанадаас авсан мэдээг орчуулж нэвтрүүлэхдээ тухайн үйл явдал, нийгмийн

үзэгдэл манай улсын аюулгүй байдал, эдийн засгийн байдал, бизнесийн орчинд ямар нөлөө үзүүлж болох эсэхийг тайлбарладаггүй. Ер нь гадаад мэдээ нь телевизийн мэдээллийн хөтөлбөрт хавсарга байдалтай байна.

Монголын телевизүүдийн хувьд

тулгамдсан өөр нэг асуудал нь өөрсдийн бэлтгэсэн нэвтрүүлгийн хувь хэмжээг нэмэгдүүлэх явдал юм. Шинэ тутам байгуулагдсан арилжааны телевизүүд гадаадын телевизийн бэлтгэсэн дуу хөгжмийн, уралдаант цэнгээнт нэвтрүүлгийг орчуулан эфирийн цагаа бөглөж байна. Харилцаа холбооны зохицуулах хороо өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ явуулж байгаа радио, телевизүүдэд тавигдах шаардлага гаргасан боловч хэрэгжилтэнд нь хэрхэн хяналт тавьж байгаа нь олон нийтэд ил тод бус байна гэж үзэж болохоор байна. Шинээр байгуулагдаад удаагүй байгаа арилжааны телевизүүдийн нэвтрүүлгийн сүлжээг харьцуулж үзэхэд бие биенээ даган

«

Үзэгчдийн сонирхол татахуйц эрчимтэй дүрс мэдээ сурвалжлагад харагддаггүй. Энэ бол бүх телевизэд байгаа нийтлэг дутагдал юм. Мэдээ, сурвалжлагын дүрс ядмаг байгаа нь сурвалжлагчийн бус, харин зураглаач, найруулагчийн хичээл зүтгэл дутсанаас болж байна.

»

дуурайсан, нэр нь өөр боловч, хэлбэр, хийцийн хувьд ялгарах юмгүй нэвтрүүлгүүд олон байгааг дурдалгүй өнгөрч болохгүй юм.

Монголын телевизүүдийн гаргадаг техникийн шинж чанартай дутагдалыг одоо тоочье. Нэгээс нөгөө суваг солих үед телевиз бүрийн дууны түвшин харилцан адилгүй байна. Нэвтрүүлгийн дундуур зарлал сурталчилгаа үзүүлэхдээ ч огцом чанга дуу хөгжим нүргэлж орж ирдэг нь бас л уучилж болшгүй алдаа. Жижиг алдаа мэт санагдавч энэ бол үзэгчдэд тааламжгүй мэдрэмж төрүүлдэг, мэргэжлийн үүднээс ноцтой дутагдал юм. Энэ бол телевизийн дууны найруулагч, инженер техникийн ажилтнууд тодорхой стандарт баримтлахгүй байгаагийн илрэл юм. Олон жилийн туршлагатай, мэргэжлийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг томоохон телевизүүд дуу, дүрсний чанарт тогтмол хэмжилт хийж хяналт тавьдаг. Харин шинэ тулгар байгуулагдсан арилжааны телевизүүдийн хувьд ийм дотоод хяналт тун сул байдаг.

Арилжааны телевизүүдийн дотоод хяналт сул байгаагийн өөр нэг нотолгоо бол цаг баримтладаггүй байдал. Хөтөлбөрт зарлагдсан нэвтрүүлэг товлосон цагаасаа хожуу эхэлдэг, зуны амралтын үед хөтөлбөрт зарлагдсан зарим нэвтрүүлгийн оронд өөр нэвтрүүлэг үзүүлэх байдал ч нэг биш удаа гарч байлаа. Мөн нэвтрүүлгийн үеэр эвлүүлгийн алдаа гарах, дэлгэцээр гаргаж буй дүрс хөдөлгөөнгүй болж гацах зэрэг хувь хүний хариуцлагагүй байдлаас үүдсэн техникийн алдаа ч арилжааны телевизэд түгээмэл байна.

Монгол Улсын 21 аймаг бүр орон нутгийн хэмжээнд нэвтрүүлэг үзүүлдэг

телевизтэй болжээ. Хүн ам ихээр төвлөрсөн Хөвсгөл аймаг, Дархан, Эрдэнэт хотод бүр 3 арилжааны телевиз ажиллаж байна. Орон телевизүүдийн ашиглаж байгаа тоног төхөөрөмж нь хоцрогдсон, хэрэглэж байгаа камер нь сонирхогчийн хэмжээний, орон нутгийн телевизэд хүний нөөц дутмаг тул ганцхан хүн зургаа авч, дуу оруулж нэвтрүүлгээ өөрөө эвлүүлж үзэгчдэд хүргэдэг тохиолдол ч байдгийг миний бие нүдээр үзсэн билээ. Нэвтрүүлгээ дамжуулж байгаа орон зай бага, зарлал сурталчилгаагаар ашиг олох боломж орон нутгийн телевизэд бараг байхгүй. Ийм нөхцөлд орон нутгийн телевизийг хөгжүүлэхийн тулд аймаг сумын телевизүүдийн хооронд нэвтрүүлэг солилцох, эсвэл нэвтрүүлгээ дамжуулах хүчин чадлыг нь нэмэгдүүлж бүс нутгийн хэмжээний телевиз байгуулвал оновчтой байж болох юм.

Монгол улсад 2008 он хүртэл Улаанбаатар хотоос нэвтрүүлгээ цацдаг телевизийн дөрвөн сувгийн хөтөлбөрийг аналог системээр хөдөө орон нутгийн үзэгчдэд хүргэдэг байсан. 2008 онд Монгол улсын Засгийн газраас зарласан тендерийн дагуу 10 сувгийг тоон системээр улс орон даяар дамжуулах ажил эхэлсэн юм. Арилжааны телевизүүдийн нэвтрүүлгийн ийнхүү улс орон даяар дамжуулдаг болсноор хил залгаа хөрш орнуудын зарим хот суурин газарт дээрх телевизүүдийн нэвтрүүлгийг үзэх боломж бүрдүүлжээ. Тухайлбал: ОХУ-ын Буриадын Улаан-Үд, БНХАУ-ын Эрээн, Хөххот, Бээжин хотод Үндэсний олон нийтийн телевиз, зарим арилжааны телевизийн нэвтрүүлэг гарч байна. Гэвч Монголын арилжааны зарим телевизийн нэвтрүүлгийг хилийн чанад

руу дамжуулах нь улс орны тухай буруу ташаа ойлголтыг хөрш орнуудын үзэгчдэд төрүүлэх эрсдэлтэй байж болох юм. Тухайлбал: TV-8 телевизийн бэлтгэдэг "Шөнийн толь" мэдээллийн хөтөлбөр нь гэмт хэрэг, хувь хүмүүсийн ялихгүй маргааныг гол төлөв үзүүлдэг. Ийм нэвтрүүлэг нь хот, орон нутгийн хүрээнд үзүүлэхэд нийцэх боловч хилийн чанадад үзүүлэх нь төдий л тохиромжтой биш юм.

Монгол Улсын харилцаа холбооны зохицуулах хороо Засгийн газраас 2010 онд баталсан "Телевиз, радиогийн зохицуулалтын талаар баримтлах чиглэл"-ийг үндэслэн 2011 онд "Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын тухай" баримт бичгийг гаргажээ. Уг баримт бичигт өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний үндсэн зарчим нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан "ардчилал, шударга ёс, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хүндэтгэж, редакцийн хараат бус байдлыг ханган баталгаажуулж, сэтгүүлчийн ёс зүйн зарчмыг баримтлан ажиллана. Өргөн нэвтрүүлэг нь үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээ-дэлж, үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлыг хамгаалан хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулна" гэсэн байна.

Үүнээс харвал Монголыг дэлхий дахинд зөвөөр таниулан сурталчилсан телевиз дутагдаж байна гэдэг үзэл санааг дэвшүүлж байна. Дэлхийн ихэнх улс орнууд үндэсний телевизийн нэвтрүүлгээ хөрш орнууд, улс төр, эдийн засаг, соёлын нягт харилцаатай бусад улс гүрнүүдийн үзэгчдэд үзүүлэхийг чармайдаг. Гадаадын үзэгчдэд зориулан эх орныхоо түүх, заншлыг сурталчилж, соёлын

нөлөөгөө нэмэгдүүлэх тусгай суваг ч ажиллуулж байна. Тухайлбал: АНУ-ын Төрийн департаментын харьяа "Америкийн дуу хоолой" радио, телевиз, ОХУ-ын "Russia today", БНСУ-ын "Ариранг" зэрэг телевизийг Монголын үзэгчид сайн мэднэ. БНХАУ-ын төв телевиз гадаадын үзэгчдэд зориулан англи, орос, франц, испани, араб хэлээр 24 цагийн турш нэвтрүүлэг дамжуулж байна.

Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизийн 2-р сувгаар дамжуулаж байгаа казах, тува хэл, буриадаар нэвтрүүлэг бэлтгэн үзүүлж байгаа нь тун оновчтой алхам болсон юм. Монголд үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны телевизүүд ч цаашдын хөгжлийн бодлогоо боловсруулахдаа дэлхийд түгээмэл хэрэглэгддэг хэлээр нэвтрүүлэг бэлтгэж бүс нутаг, олон улсын хэмжээнд үзэгчтэй болох талаар анхаарууштай. Монгол улсыг сурталчлах, монгол хүний үнэлэмжийг дээшлүүлэх, олон улсын тавцанд болж байгаа асуудалд Монголын дуу хоолой, байр суурийг тогтмол илэрхийлж байх телевизийн суваг манай улсад зайлшгүй хэрэгтэй юм.

Ишлэл

- ¹ Норовсүрэн Л., Ариунзаяа Н. 2009. Телевизийн сэтгүүл зүй. УБ., 199 дэх тал.
- ² Строкач А. А. 2001. Основы радио-телевизионной журналистики. М., с. 47.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
2. Наранжаргал Х. 2006. Телевизийн сэтгүүл зүй: үндсэн ойлголт, зөвлөмж. УБ.
3. Норовсүрэн Л., Ариунзаяа Л. 2009. Телевизийн сэтгүүл зүй. УБ.

Резюме

4. Шаравдорж Н. 1997. Зурагт зулын хойморт заларсан нь. УБ.
5. Строкач А. А. 2001. Основы радиотелевизионной журналистики. М.
6. Цвик В. Л. 2002. Телевизионная журналистика. М.
7. Юровский А. Я. 2002. Телевизионная журналистика. М.

В настоящей статье автор затрагивает проблемы развития телевидения Монголии. Анализируя уровень развития телевидения страны и конкретные проблемы, автор предлагает возможные варианты решения.